



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/449

Мандалговь

Орос хэл, соёлын арга хэмжээ зохион
байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 16 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100, Монгол Зөвлөлтийн хамтарсан сансрын нислэгийн 40 жилийн ойн хүрээнд Бүгд Найрамдах Буриад Улсын Соёлын Гавьяат ажилтан, орос хэлний багш, профессор Ё.Максимын нэрэмжит “Орос хэл, соёлын баяр” арга хэмжээг зохион байгуулахад зарцуулах 3,440,000 (гурван сая дөрвөн зуун дөчин мянган) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээнд шаардагдах 3,440,000 (гурван сая дөрвөн зуун дөчин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны 19 дугаар сарын
07 -ны өдрийн 1 дугаар захирамжийн хавсралт

ОРОС ХЭЛ, СОЁЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Олимдиадын төлөөлөгч, багш нарын өдрийн хоол	50	9,000	450,000
2	Хоолны сав	50	1,000	50,000
3	Аймгийн Засаг даргын хүлээн авалт	62	30,307	1,879,000
4	Сөнгийн хувин	1	300,000	300,000
5	Сөнгийн хувин	1	280,000	280,000
6	Бэлэг дурсгал /жижиг тэмээ/	17	13,000	221,000
7	Баннер	32,5	8,000	260,000
	Нийт дүн		3,440,000	